



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 сарын 22 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 288.5 дахь хэсэг нэмсүгэй:

“288.5. Аймаг, сумын Засаг дарга тухайн нутаг дэвсгэр дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, дэд даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авна.”

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 187 дугаар зүйлийн 187.1.3 дахь заалтын “ажиллах” гэсний дараа “, тогтоолын биелэлтийг хойшлуулсан насанд хүрсэн этгээдийг зохих ажлын байраар хангахад туслалцаа үзүүлэх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1 дэх хэсгийн “тавина.” гэснийг “тавьж, харилцан хамтран ажиллана.” гэж, 189 дүгээр зүйлийн 189.5 дахь хэсгийн “үзүүлнэ” гэснийг “үзүүлж, хамтран ажиллана” гэж, 203 дугаар зүйлийн 203.2.4 дэх заалтын “нийслэл, сум,” гэснийг “сум, нийслэл,” гэж, 239 дүгээр зүйлийн 239.2, 239.7 дахь хэсгийн “дүүрэг, баг” гэснийг “баг, дүүрэг” гэж, 288 дугаар зүйлийн 288.5 дахь хэсгийн дугаарыг “288.6” гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР